




15th Story

Иерусалим руу

ОРСОН НЬ


Triumphal Entry




Иерусалим руу орсон нь!

– 15th Story –

- Өгүүлэгч** Нэгэн өдөр, Есүс болон шавь нар нь Иерусалим руу явж байлаа. Тэд Чидун ууланд дөхөж ирэх үед Есүс шавь нартаа хэлэв.
- Есүс** Ах дүүс минь, доод тосгон руу оч. Тэнд очвол нэг уяатай илжиг дудрантайгаа байгаа. Тайлаад Над руу аваад ир.
- Иохан** Хэрэв эзэн нь болохгүй гэвэл яах вэ?
- Есүс** Хэрэв хэн нэгэн та нарт юм хэлбэл “Эзэнд хэрэгтэй” гэж хэлээрэй. Тэгвэл даруй явуулна.
- Иаков** За ойлголоо. Явцгаая.
- Сони** Хөөх. Ямар сайхан өдөр вэ!
- Кристофер** Нээрээ тийм байна, аав аа! Тэнд тэр хүмүүс хэн бэ?
- Сони** Харин ээ, хамт очиж үзэх үү?
- Иаков** Сайн байна уу. Мм.. танай илжиг хэрэг болоод оо
- Тариачин** Юу? Яагаад?
- Иохан** аан. Эзэн хэрэглэх гээд
- Тариачин** Эзэн? Танай Эзэн үү?
- Бартоломай** За, тиймээ
- Иаков** Тийм ээ, Эзэн гэж дууддаг
- Тариачин** Та нарын Эзэн чинь Эзэн гэж дээдлэгдэх хэмжээний мундаг юмуу?
- Бартоломай** Тиймээ
- Иаков** Хөөе, бид Таны илжигнүүдийг авч явахаар ирлээ. Манай Эзэн Танд ингэж хэл гэсэн юм. “Эзэнд хэрэгтэй” гэж хэл гэсэн.
- Тариачин** Байзаарай, нэг л ойлгохгүй байна. Изриалийн Бурханыг хэлж байна уу?
- Иаков, Иохан, Бартоломай** Тийм ээ! Мөн!
- Тариачин** Өө за ... надаар тоглоод байна уу!
- Иаков** Үгүй ээ, тоглоогүй
- Бартоломай** Үнэхээр тоглосон юм биш
- Иохан** Манай Эзэн одоо биднийг хүлээж байгаа. Илжигнүүдийг дагуулаад явж болох уу?
- Тариачин** Тэгэлгүй яахав. Дагуулаад яваарай. Өөр хэрэгтэй зүйл байхгүй юу?
- Иохан** Үгүй ээ үгүй. Эд нар л байхад хангалттай. Баярлалаа.



Иаков	Баярлалаа
Тариачин	зүгээр дээ
Бартоломай	Танд бидний Эзэний ерөөл хамт байх болтугай
Тариачин	Баярлалаа
Сони	Өө, Кристофер, бид үнэхээр чухал ажил хийхээр явж байгаа юм шиг байна.
Кристофер	Ямар ажил вэ, аав аа?
Сони	сайн мэдэхгүй байна. Гэхдээ битгий айгаарай.
Кристофер	За.
Иаков	Илжигнүүд ээ, бидэнтэй хамт томоотой явна шүү, за юу?
Иохан	Багшаа, таны хэлсэн илжигнүүдийг аваад ирлээ.
Есүс	сайн байна
Сони	Хөөх!, энэ чинь зүүд үү, жинхэнэ үү! Есүс байна ш дээ! Миний эртний найз, Есүс!
Кристофер	Хэн бэ?
Сони	Бид хамт өссөн. Есүсийг цөл рүү явснаас хойш нэг ч удаа уулзаж байсангүй. Тэгээд намайг өөр газар руу явуулчихсан байхгүй юу. Кристофер, тэр бол үнэхээр маш чухал Нэгэн.
Кристофер	Ямар чухал хүн болоод тэгнэ вэ? Мундаг хүн байлаа гээд шалихгүй биз.
Сони	Кристофер, Тэнгэр рүү өлийн хараач. Тэгээд газрыг хар. Тэгээд намайг хар. Бас энэ хүмүүсийг хар. Бурхан энэ дэлхийн бүх зүйлсийг бүтээсэн, тийм биз? Есүс бол Бурханы Хүү. Одоо чиний урд байгаа тэр Нэгэн бол Бурханы Хүү.
Кристофер	Юу гэнээ? Хачирхалтай юм. Нээрээ юу??
Сони	Нээрээ, бид одоо маш чухал ажлыг хийх болсон шүү!
Кристофер	Хөөх!!!
Есүс	Тиймээ, бид одоо Иерусалим руу орно. Би тэр дудранг унаад явна. Учир нь хуучин гэрээний Зехариа эш үзүүлэгчээр дамжуулан өгсөн үгийг биелүүлэхийн тулд юм. Зехариа эш үзүүлэгч зөгнөн хэлэхдээ, “Харагтун, Хаан Эзэн чинь чам уруу даруухнаар, илжиг буюу эдэлгээний адгуусын төл, дудран унаад айсуй гэж Сион охинд дуулга» гэсэн”
Кристофер	Аав аа! Би байна!
Петр	энд байна Есүс ээ. Миний гадуур хувцсан дээр сууна уу
Андрей	Миний хувцсыг ч бас
Олон түмний нэг	Хөөх, хар даа. Тэр Есүс юм шиг байна?
Олон түмний нэг 2	Нээрээ юу? Хөөх, Есүс илжиг унаад Иерусалимд орж ирлээ~~



Олон түмний нэг	бүгд хурдлаарай~~ хурдан очиж үзье, хурдлаарай!
Олон түмэн	Тэрийг хараа, Есүс байна. Есүс. —Давидын Хүүд Хосанна! Эзэний нэрээр Ирэгч нь ерөөлтэй еэ! Хамгийн Дээдэд Хосанна!
Кристофер	Аав аа үнэхээр гайхалтай. Есүс үнэхээр Бурханы Хүү юм байна.
Хотын төрийн алба хаагчид	хөөе хөөе, тэнд юу болоод байна? Тэр хүн хэн бэ?
Олон түмний нэг 3	Энэ хүн бол Есүс. Галилын Назараас ирсэн эш үзүүлэгч Есүс байгаа юм.
Хотын төрийн алба хаагчид	Юу гэнээ?
Есүс	Сүм рүү очицгооё.
Шавь нар	За, Эзэн минь
Өгүүлэгч	Маш эрт үед зөгнөсөн ёсоор Есүс дудран унаад Иерусалим руу орж ирсэн. Есүс сүм рүү орох үед тэнд өрнөж буй явдлаас болж ихэд уурлан, тэнд байсан хүмүүс рүү гүйн очсон.
Есүс	Боль, бүгд больцгоо
Худалдаачин	Юу хийж байгаан бэ?
Худалдаачин 2	Яагаад ингэнэ вэ? Би ажлаа л хийж байна...
Өгүүлэгч	Есүс сүмд ороод худалдаачдыг болон худалдагчдыг бүгдийг хөөгөөд, мөнгө солигчдын ширээнүүд, тахилд хэрэглэдэг тагтаа зардаг хүмүүсийн сандлыг хөмөрч орхисон.
Есүс	Библид тэмдэглэснээр, “Миний гэр залбирлын гэр гэж нэрлэгдэх болно” гэв. Гэтэл та нар түүнийг нь дээрэмчдийн үүр болгож байна.
Худалдаачин	хөөе, бид бараагаа яах юм бэ?
Есүс	Орхиод явцгаа, одоо хурдан
Худалдаачин 2	За ойлголоо, та ч галзуурчээ
Өгүүлэгч	Есүс ажлаа дуусах үед фарисайчууд бухимдав. Есүсийг Иерусалим руу орж ирэхэд хүмүүс Түүнийг магтан алдаршуулсан бөгөөд Иерусалимд орж ирээд Бурханы өргөөнд хийсэн зүйлсийг зохисгүйд тооцсон. Тэд Есүсийг хөнөөх арга хайсан боловч хүмүүс Есүст ам сайтай, Түүнийг сонсох маш дуртай байсан учраас дураараа хийх боломжгүй байв.